

ОНГОН СУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2022.10.28

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ИТХ-ын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулсан.

Багуудын өдөрлөгийг 10 дугаар сарын 15-24-ний өдрүүдэд зохион байгуулж, иргэдэд төрийн албаны мэдээлэл, орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг мэдээлсэн.

Аймгийн засаг даргын 07 тоот албан даалгаварыг байгууллагын удирдлагуудад хүргэн, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжитэд хяналт тавьж ажиллаж байна.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Аймгийн аудитын газраас сумын төсвийн орлогын төлөвлөлтөд аудит хийгдэж, өмнөх шалгалтын актын хэрэгжилтийг шалгасан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд

Хамтарсан баг, цагдаагийн хэсэг хамтран ЕБС, цэцэрлэгийн сурагч, хүүхэд багачуудыг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг, эх асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр сургууль, сурагчдын дотуур байр, цэцэрлэгийн хяналтын камерийн үйл ажиллагаанд шалгалт хийж, ажиллахгүй байгаа камеруудыг ажиллагаатай болгох хугацаатай үүрэг өгч бүрэн ажилладаг болгосон.

Мөн Хамтарсан баг, цагдаагийн тасгаас сурагчдын дотуур байранд аюулгүй байдлын эргүүл, шалгалтыг 1 удаа явуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сурагчдын дунд “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэм, “Сургуулийн эргүүл” /School police/-ийн үйл ажиллагааг сурталчлах ажил зохион байгуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн.

Сумын хэмжээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ГХУСЗ-өөс иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал оруулж, 1.128.000 төгрөгийг шийдвэрлүүлж, замын тэмдэг, тэмдэглээг шинээр хийлгэж ЕБС, цэцэрлэг, нийтийн эзэмшил газруудад байрлуулсан.

Нийгмийн бодлогын ажлын хэсгээс зохион байгуулсан Хамтарсан баг, салбар зөвлөлийн хамтын ажиллагааг сайжруулах зөвлөмжид сумын удирдлагууд, байгууллагын дарга нарыг оролцуулсан.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ёс зүйн салбар зөвлөлөөс “Багшийн андгай өргөх” арга хэмжээг зохион байгуулав.

Ерөнхий боловсролын сургуулийн ЁЗСЗ-өөс 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг аян”-ыг 1 сарын хугацаатай зохион байгуулж байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Хэлмэгдүүлэлт миний нүдээр” илтгэлийн уралдаан зохин байгуулсан.

Гурав. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчилах ажлын хүрээнд ЕБС-ийн монгол хэлний танхимаас “Бийрийн бичлэг”-ийн дугуйланг 7 хоногт 2 цагаар төлөвлөн зохион байгуулж байна.

Олон улсын “Охидын өдөр”-өөр 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “Хүчирхэг охид” өдөрлөгийн арга хэмжээг тэдний санал бодлыг сонсох, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх хэлэлцүүлэг, лекц, ярилцлага хэлбэрээр зохион байгуулсан. Хамтарсан баг, ЕБС хамтран “Охид бид юу хүсдэг вэ” илтгэлийн уралдаан зохион байгуулсан. /12 сурагч оролцсон/

“Сумын хөгжилд-Залуусын оролцоо” залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж, ЗСЗ-ийг шинэчлэн байгуулсан.

Сумын нийтийн номын санд шинэ номын баяжилт хийж, 26 нэрийн 45 ширхэг хүүхдийн номыг олгосон.

Соёлын төвөөс “Багш нарын өдөр”-т зориулсан “Багш нар дуулж байна” тэмцээн зохиож 25 багш оролцсон.

Соёлын биет бус өвийн үзлэг тооллогыг Соёлын яамны багтай хамтран зохион байгуулж 5 өв тээгчийг бүртгэн баримтжуулсан.

Хунгийн баяр арга хэмжээний нээлтэд морин хуурч, уртын дуучдын хамт оролцсон.

“Найргийн орны найрагч хүүхдүүд” шүлгийн уралдаан зохион байгуулж 64 хүүхэд оролцож 12 хүүхэд шагналт байрт шалгарсан.

Ахмадын нийтийн бүжиг, залуучуудын чуулга уулзалтын соёл олон нийтийн арга хэмжээг удирдан зохион байгуулсан.

“Сумын хамтарсан баг”-ийн хурлыг 1 удаа зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирчийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгаа өгсөн.

Дөрөв: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Аймгийн засаг даргын 06 тоот албан даалгаврыг хэрэгжилтийг гаргаж, ХАА-н газарт хүргүүлсэн, хэрэгжилт 82 хувьтай.

Үржлийн малын үзлэг, ангилалт, ээмэгжүүлэлтийг зохион байгуулсан./1 хувьд хийгдсэн/

Оготно устгалын ажлыг үргэлжлүүлж хороор устгах ажлыг хийж гүйцэтгэв.

Намрын мод тарилтын “Бүх нийтээр мод тарих өдөр” сумын төвийн нийтийн эзэмшил газарт 700 ш мод тарьж бүртгэлжүүлэв, 6 байгууллага, 153 иргэн хамрагдсан.

Сумын төвд гэрэлтүүлэг, зам засварын ажлыг “Ёст бээс сервис” ХХК гүйцэтгэж байна.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ